

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Байршил: Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Эхлэх хугацаа: 2026/06/22

Дуусах хугацаа: 2026/07/22

Ажил эхлэх хугацаа: 2026/08

Цалин: Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ ДАРГА

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:

- Байгууллагын хүний нөөцийн бодлого, стратегийг боловсруулах, хэрэгжилтийг хангах
- Хүний нөөцийн албаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах
- Хүний нөөцийн хэрэгцээ, төлөвлөлтийг тодорхойлж, бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтыг удирдах
- Ажилтнуудын сургалт, хөгжлийн бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх
- Гүйцэтгэлийн удирдлага, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгож, хэрэгжүүлэх
- Хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлыг хууль, журмын хүрээнд шийдвэрлэх
- Удирдлагыг шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах, тайлагнах

Тавигдах шаардлага:

- Хүний нөөцийн удирдлага, бизнесийн удирдлага, эрх зүйн чиглэлээр магистраас доошгүй зэрэгтэй байх;
- Мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил, үүнээс удирдах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- Хүний нөөцийн бодлого боловсруулах, хөдөлмөрийн харилцааны талаар мэдлэгтэй байх
- Удирдан зохион байгуулах, манлайлах, төлөвлөх, шийдвэр гаргах ур чадвартай байх
- Өгөгдөлд суурилсан шинжилгээ хийх, тайлагнах чадвартай байх
- Англи хэлний ярианы болон бичгийн ахисан (B2) болон түүнээс дээш түвшний мэдлэгтэй байх

Бүрдүүлэх материал:

- Ажилд орох өргөдөл
- Товч намтар - CV
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон батламжийн хуулбар
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа – 2 хувь

Холбоо барих:

Та баримт бичгээ англи, монгол хэл дээр бэлтгэн 1 PDF файл болгон эмхэтгэж recruitment@gmit.edu.mn хаягаар бидэнд ирүүлнэ үү.

Цахим хуудас: www.gmit.edu.mn

Утас: +976 7023-2090

Жич: Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярилцлагад урих болно.